

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 07 дугаар сарын 09-ний “Мягмар” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ЗДТГ, Ажлын хэсэг, ААНБ-ууд
2	Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах.	ТХҮХ
3	Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг сайтар зохион байгуулах.	ОБХ, Холбогдох байгууллагууд
4	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангах.	ТХҮХ, Нийт байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
5	Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгавар болон бусад хугацаат тайлан биелэлтийн хэрэгжилтэд анхаарч, гүйцэтгэлийг сайжруулан албан хаагчдын ээлжийн амралтыг олгохдоо ажлын тасралтгүй хэвийн байдалд анхаарах.	Нийт байгууллагууд
6	Гэрэлтүүлгийн асалтыг 100 хувьд хүргэж, шонгуудыг тэгшлэх, будаж өнгө үзэмжийг сэргээх ажлуудыг яаралтай зохион байгуулж дуусгах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
7	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэж буй ажлуудад тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийг сайжруулах. Үүнд: - Орцны засвар; - Фасад засвар; - Баруун жигүүрийн шугам солих ажил; - “Алтай” бүлгийн засвар; - Сургуулийн цайны газрын засвар, замын ажил;	Холбогдох байгууллагууд
8	“Хангай парк-1” “Хангай парк-2” цэцэрлэгт хүрээлэнгүүдийн усан оргилуур, гэрэлтүүлэг болон бусад эд зүйлсийн эвдрэл гэмтлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
9	Байгууллагууд өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн шарилж, хогийн ургамлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах.	Нийт байгууллагууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР